



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ АЖЛЫН АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

Гадаадад томилолтоор ажиллуулах тухай


Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3, Улсын Их Хурлын 2006 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм”-ийн 4.5.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны Судалгаа, эрсдэлийн шинжилгээний хэлтсийн мэргэжилтэн А.Бадамсүрэнг Олон улсын валютын сангаас 2018 оны 02 дугаар сарын 04-ний өдрөөс 11-ний өдрүүдэд Сингапур улсад зохион байгуулагдах “Санхүүгийн зохицуулалтын орчинд тулгарч буй асуудлууд” сэдэвт сургалтад зохион байгуулагч талын санхүүжилтээр оролцуулсугай.

2. А.Бадамсүрэнгийн Сингапурт ажиллах удирдамжийг хавсралтаар баталсугай.


3. Гадаад томилолтын тайланг 2018 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн дотор танилцуулахыг А. Бадамсүрэнд, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа удирдлагын газар /Б.Батзориг/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА



Т.ЖАМБААЖАМЦ

Ажлын албаны даргын 2018 оны
01 дүгээр сарын 31-ны өдрийн
17-т тоот тушаалын хавсралт



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ГАДААД АЛБАН ТОМИЛОЛТЫН УДИРДАМЖ

Арга хэмжээний нэр:

“Санхүүгийн зохицуулалтын орчинд тулгарч буй асуудлууд” сэдэвт сургалт

Арга хэмжээг зохион байгуулагч:

Олон улсын валютын сан

Хаана:

Сингапур улс

Хугацаа:

2018 оны 02 дугаар сарын 04-ний өдрөөс 11-ний өдрүүдэд

Арга хэмжээнд оролцогчийн овог нэр, албан тушаал:

А.Бадамсүрэн, Судалгаа, эрсдэлийн шинжилгээний хэлтсийн мэргэжилтэн

Арга хэмжээнд оролцох зорилго:

Уг сургалтын үндсэн зорилго нь банк болон банкнаас бусад санхүүгийн байгууллагуудын салбарын асуудлуудад чиглэгдсэн. Банкны салбарын хүрээнд Базел III капитал, хөшүүрэг болон төлбөрийн чадварт тавигдах шаардлага, зохицуулалтын талаар хэлэлцүүлэг зэрэг сэдвүүдээр яригдах бол банкнаас бусад санхүүгийн салбарын хүрээнд дериватив, үнэт цаасыг буцаан худалдан авах гүйлгээ болон зээлдүүлэх, харилцагчийн эрсдэлийн удирдлага, мөн барьцаа хөрөнгийн зах зээл дэх төв банкуудын үүрэг зэрэг сэдвүүд яригдах юм.

Монгол улсад олон тулгуурт, хөгжсөн санхүүгийн зах зээлийг бий болгоход хөрөнгийн зах зээлийн хөгжлийг дэмжих нь чухал үр нөлөөтэй. Тэр дундаа үүсмэл санхүүгийн хэрэгсэл буюу деривативын зах зээлийг хөгжүүлэх нь хөрөнгийн зах зээлд арилжаалагдаж буй бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэхээс гадна зах зээлийн хөрвөх чадварыг нэмэгдүүлэх гол үүрэгтэй. Мөн деривативын зах зээлд харилцагч талынхаа эрсдэлийг судалж дүгнэх нь ирээдүйд алдагдалд орох, мөн дампуурах эрсдэлүүдийг бууруулж өгдөг учраас эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж эхлэх нь мөн зах зээлийг хөгжүүлэх бас нэгэн үндэс суурь болж өгнө.

Иймд энэхүү сургалтад сууснаар дээрх сэдвүүдийн хүрээнд манай оронд хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэхэд чухал шаардлагатай мэдээ мэдээлэлтэй танилцаж, мөн бусад улс орнуудтай хөрөнгийн зах зээлийн хөгжлийнх нь талаар туршлага солилцох зорилготой.

Арга хэмжээнд оролцсоноор гарах үр дүн:

- Сургалтад сууснаар, дериватив болон деривативын нэр төрөл, үнэт цаасыг буцаан худалдан авах, зээлдүүлэх үйл явц, мөн эдгээрийн зохицуулалтын талаар суралцах;
- Деривативын зах зээл дээр харилцагчийн эрсдэлийн удирдлагыг хэрхэн хэрэгжүүлж зохицуулдаг талаар судалж суралцах;
- Бусад улс орнуудын төлөөлөгчидтэй уулзан тус оронд хөрөнгийн зах зээлийг деривативаар дамжуулж хэрхэн хөгжүүлсэн туршлага, тулгарч буй хүндрэл бэрхшээл, түүнээс хэрхэн гарах талаар авч буй арга хэмжээний талаар судлах;
- Ижил төстэй байгууллагууд деривативын зах зээлийг хэрхэн бодлогоор зохицуулж, хөгжүүлж байгаа талаар судлах.